



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/107

Мандалговь


“Одда тайж” ХХК-тай гэрээ байгуулах тухай”

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Цэцэрлэгийн барилгын их засвар (Дундговь, Өлзийт сум)”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Одда тайж” ХХК-тай 278,877,343 (хоёр зуун далан найман сая найман зуун далан долоон мянга гурван зуун дөчин гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Цэцэрлэгийн барилгын их засвар (Дундговь, Өлзийт сум)” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Одда тайж” ХХК-ийн захирал (Д.Ундармаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Өлзийт сумын Засаг дарга (А.Эрдэнэбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.



482060440